



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан¹)

БУСДЫН ОРОН БАЙРАНД ЗӨВШӨӨРӨЛГҮЙ НЭВТЭРЧ БЭЛГИЙН ДУР ХҮСЛЭЭ ХАНГАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ДООД ТАЛ НЬ 7 ЖИЛИЙН ХОРИХ ЯЛ ОНООХ НЬ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2021 хнга 9 등 31 통합된 사건

Шүүхийн шийдвэрийн огноо: 2023 оны 02 дугаар сарын 23

Шийдвэрийн төлөв: Маргаан бүхий заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай тусгай хууль ² (сол. 성폭력범죄의 처벌 등에 관한 특례법)-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн 319 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох гэмт хэрэг үйлдсэн этгээд уг хэргийг үйлдэхдээ мөн хуулийн 298-р зүйл “Хүч хэрэглэн бэлгийн дур хүслээ хангах”, 299-р зүйл “Бэлгийн дур хүслээ хангахаар завдсан” гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд бүх насаар нь хорих эсхүл 7-оос дээш жил хорих ялаар шийтгэнэ” гэж гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг 7 жил байхаар заажээ. Ийнхүү хуульчилсан нь Үндсэн хуулийн суурь зарчим болох тэгш байдлын зарчим (сол. 평등원칙), тэнцвэрийн зарчим (сол. 책임과 형벌 사이의 비례원칙)-тай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт хийлгэх тухай Бүгд Найрамдах Солонгос Улсын анхан, давж заалдах шатны нийт 25 шүүх болон гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа нийт 7 шүүгдэгч Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл, хүсэлт гаргасан.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Бүгд Найрамдах Солонгос Улсын Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай тусгай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт 2020 оны 05 сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://isearch.ccourt.go.kr/view.do>

² Бүгд Найрамдах Солонгос Улсын Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай тусгай хууль, 2010 он. <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?lsId=011187&ancYnChk=0#0000> (Сүүлд үзсэн: 2025.05.29)



Хуульд нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө бусдын орон байранд зөвшөөрөлгүй нэвтэрч хүч хэрэглэн бэлгийн дур хүслээ хангах, хүч хэрэглэн бэлгийн дур хүслээ хангахаар завдсан гэмт хэрэгт бүх насаар нь хорих, эсхүл доод тал нь 5-аас дээш жил хорих ялаар шийтгэнэ гэж хуульчилж байжээ. Харин хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр бүх насаар нь хорих буюу 7-оос дээш жил хорих ялаар шийтгэнэ гэж ялын доод хэмжээг нэмэгдүүлсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж дараах үндэслэлээр дүгнэлт гаргажээ.

1. Бүгд найрамдах Солонгос улсын Үндсэн хууль ³(сол. *대한민국 헌법*)-ийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэний эрх, эрх чөлөөг зөвхөн үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам сахиулах, нийтийн сайн сайхны төлөө шаардлагатай үед зөвхөн хуулиар хязгаарлаж болох ба ингэхдээ эрх, эрх чөлөөний үндсэн агуулгыг зөрчиж үл болно” гэж заасан байдаг. Шаардлагатай үед үндсэн эрхийг хязгаарлахад үндсэн 3 зарчим баримтлах бөгөөд үүний нэг нь тэнцвэрийн зарчим юм. Маргаан бүхий заалтын хувьд шүүгдэгчийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлаж, ялын доод хэмжээг тогтоохдоо тэнцвэрийн зарчмыг баримтлах ёстой.
2. Хууль тогтоогч бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг бууруулах, уг гэмт хэрэг өссөнтэй холбоотой нийгмийн бухимдлыг багасгах зорилгоор ялын хэмжээг нэмэгдүүлсэн байж болно. Гэвч “иргэдийн уур бухимдал” их байгаа нь ялын доод хэмжээг нэмэгдүүлэх үндэслэл болохгүй, мөн ялын доод хэмжээг нэмэгдүүлснээр гэмт хэрэг буурна гэж үзэх нь өрөөсгөл ойлголт юм гэжээ.
3. Иймд маргаан бүхий заалтын хувьд тус гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг тогтоохдоо ялын зорилгод нийцэх хэмжээг хэтрүүлэн тогтоосон буюу ялтны эрхийг хязгаарлахдаа Үндсэн хуулийн суурь зарчим болох тэнцвэрийн зарчмыг алдагдуулсан байх тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна гэжээ.

---o0o---

³ Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль, 1987 он.
<https://www.law.go.kr/lsEflInfoP.do?lsiSeq=61603#J37:0> (Сүүлд үзсэн:2025.05.29)

